



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2015 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 246

Улаанбаатар хот

Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 271,<sup>1</sup>  
273 дугаар тогтоолоор батлагдсан журам, шаардлагад  
өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3, 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Урт хугацааны даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 10, 17<sup>1</sup>, 17<sup>2</sup> дахь заалтуудыг дараах байдлаар өөрчлөн найруулсугай:

1/ 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 10, 17<sup>1</sup>, 17<sup>2</sup> дахь заалтууд:

	Хөрөнгийн ангилал	Хөрөнгө байршуулах дээд хувь	Зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн хувь
Заалт	Баганын дүн	1	2
10	Хөрөнгө оруулалтын сан /Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 6.2.1-д заасан нээлттэй, эсхүл хаалттай санг ойлгоно./	20%	Нээлттэй сан: 5% Хаалттай сан: 10%
17 <sup>1</sup>	МХБ-ийн хувьцаат компанийн хувьцаа	I ангилал	10%
		II ангилал	5%
17 <sup>2</sup>	Тухайн даатгалын компанийн холбогдох этгээдэд үл хамаарах банк бус санхүүгийн байгууллагад итгэлцлээр байршуулах мөнгөн хөрөнгө	20%	5%

2/ Дээрх өөрчлөлтийг оруулсантай холбоотойгоор тус журмын хавсралтын холбогдох мөрүүдийг дараах байдлаар өөрчилсүгэй:

3.Зөвшөөрөгдөхгүй хөрөнгө	Дүн	Бууруулах хувь	Тохиргоо хийгдсэн дүн
---------------------------	-----	----------------	-----------------------

000366

Хөрөнгө оруулалтын сан /Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 6.2.1-д заасан нээлттэй, эсхүл хаалттай санг ойлгоно./		Нээлттэй сан: 5%	
		Хаалттай сан: 10%	
МХБ-ийн хувьцаат компанийн хувьцаа	I ангилал	20%	
	II ангилал	30%	
Тухайн даатгалын компанийн холбогдох этгээдэд үл хамаарах банк бус санхүүгийн байгууллагад итгэлцлээр байршуулах мөнгөн хөрөнгө		5%	

2. Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 273 дугаар тогтоолоор батлагдсан “Урт хугацааны даатгагчийн хөрөнгөөс хөрөнгө оруулалт хийх хөрөнгийн хэмжээ, түүнд тавигдах шаардлага”-ын 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10, 12, 13 дахь заалтуудыг дараах байдлаар өөрчлөн найруулсугай:

1/3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10, 12, 13 дахь заалт:

Хөрөнгийн ангилал		Хөрөнгө оруулах дээд хувь
Заалт	Баганын дүн	1
10	Хөрөнгө оруулалтын сан /Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 6.2.1-д заасан нээлттэй, эсхүл хаалттай санг ойлгоно./	20%
12	МХБ-ийн хувьцаат компанийн	I ангилал
	хувьцаа	II ангилал
13	Тухайн даатгалын компанийн холбогдох этгээдэд үл хамаарах банк бус санхүүгийн байгууллагад итгэлцлээр байршуулах мөнгөн хөрөнгө	20%

3. Энэхүү тогтоолыг батлагдсан өдрөөс хойш даатгалын нөөц сангаас үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээл олгохыг хориглоно.

4. Дээрх журам, шаардлагад өөрчлөлтүүдийг оруулж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Батсэлэнгэ/-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА